

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрхлэх асуудлын хүрээний
байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэл**

АУДИТЫН КОД: САГ-2018/12СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын хураангуй тайлан	2
2	Аудитын гэрчилгээ	6
3	Аудитын тайлан	8
3.1	Оршил	8
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	8
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	9
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
3.5	Дотоод аудит.....	10
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
3.7	Шилэн дансны мэдээлэл	11
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	12
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	12
3.9.1	Санхүүгийн тайлангийн аудитын талаар	12
3.9.2	Санхүүгийн тайлагналын талаар.....	13
3.9.3	Үндсэн хөрөнгийн талаар.....	13
3.9.4	Мөнгөн хөрөнгийн талаар.....	14
3.9.5	Авлага, өглөг, урьдчилж төлсөн зардлын талаар.....	14
3.9.6	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар	15
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	15
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд	16
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	16
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	16
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	17
3.16	Аудитын үр өгөөжийн талаар	17
4	Менежментийн захидал.....	18
4.1	Санхүүгийн тайлангийн аудитын талаар	19
4.2	Санхүүгийн тайлагналын талаар	20
4.3	Авлага, өглөг, урьдчилж төлсөн зардалын талаар	21
4.4	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар	22
5	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	23
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	23
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	24
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	25
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	26
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	27
6	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	29
7	Албан шаардлага.....	30



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ЛҮНДЭНДОРЖ ТАНАА

2018.04.25 № 1041

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна. Иймд "хязгаарлалттай" санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG31.Docx

070469

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудитын гол асуудал

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд

- Булган аймгийн Шүүхийн тамгын газарт санхүүгийн аудитын санал дүгнэлт өгөхөөс татгалзсан /937.3 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай/ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "... байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй".
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тушаал, шийдвэргүйгээр 403.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.4-т "... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх ... саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, ... шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ",
- Авлага, өглөгийн нийт 22.8 сая төгрөгийн тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "тасралтгүй", 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...", 20.2.6-д "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д ХҮРЭЛБААТАР

\\10.10.10\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2018\0425SAG31.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3 Аудитын тайлан

3.1 Оршил

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд тус Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд санхүүгийн тайлангийн аудит, санхүүгийн тайлагнал, авлага, өглөг, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 5-наас 2018 оны 4 дүгээр сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн



ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж, аудитор Ц.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01/299 дүгээр албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын Шүүхийн захиргааны тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах;
- Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах;
- Шүүгчийг хуульчдаас шилж олох;
- Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- Шүүхийн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- Ерөнхий зөвлөл нь анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд ажлаа тайлагнах зэрэг болно.

Шүүхийн ерөнхий зөвлөл дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Шүүхийн ерөнхий зөвлөл тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 1 арга хэмжээ төлөвлөснөөс 97 хувийн биелэлттэй байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5 дүгээр тэмдэглэв.



Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар, аудитын 14 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.


Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудитын алба Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудитын алба тайлант онд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомж, бодлого хэрэгжилтийг хангах стратегийн зорилт, зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэх ажил, дотоод ажил үйлчилгээ гэсэн 4 бүлэг төлөвлөгөө батлуулсан байна.

Хүснэгт 1. Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	36	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	33	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	33	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	76
		Дүн (сая.төг)	86.2
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	76
		Дүн (сая.төг)	86.2
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	-
		Дүн (сая.төг)	-

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн Дотоод аудитын албаны 2017 оны тайлан



2017 оны дотоод аудитын шалгалтаар нийт зөрчлийн 35.0 хувь нь автомашин хэрэглэх журам зөрчсөн, 18.0 хувь нь анхан шатны баримт дутуу бүрдүүлсэн, 15.0 хувь нь өр авлага үүсгэсэн, 12.0 хувь нь шилэн дансны мэдээлэл хугацаанд нь оруулаагүй, 10.0 хувь нь ажилчдын хангалтгүй цагийн бүртгэл үндэслэн цалин хөлс бодсон зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн бөгөөд тухай бүр нь залруулж 86.2 сая төгрөгийн зөрчилд 76 зөвлөмжийг хүргүүлэн ажиллажээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудитыг цаг тухайд нь аудит хийж зөрчил дахин гаргахгүй байх тал дээр анхаарч ажилласны дүнд өмнөх зөвлөмжийг биелүүлсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 46,731.3 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 0.7 хувь буюу 323.5 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Тухайлбал:


- ✓ Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны орон тоог бууруулан шинэ бүтцээр ажиллаж, орон тооны цомхтголд орсон мэргэжлийн боловсон хүчнийг шүүхийн тамгын газарт шилжүүлснээр тэтгэмжийн зардал 121.8 сая төгрөгөөр,
- ✓ Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн шүүгчийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Ерөнхийлөгчийн зарлиг 2017.12.29-ний өдөр гарсанаар тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн тэтгэмж 65.5 сая төгрөгөөр,
- ✓ Төрийн албан хаагчид олгох ажлын үр дүнгийн урамшууллыг сахилгын арга хэмжээтэй албан хаагчдад олгоогүйгээс 12.8 сая төгрөгөөр,
- ✓ Зөрчлийн тухай хууль, иргэн, эрүү, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад заасан шүүхийн зардлыг зарим хуулиуд нь оны дундуур хэрэгжиж эхэлсэнээр 62.1 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад төлөвлөсөн зардлууд бүлгийн дүнгээр хэтрээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн бүрэлдэхүүн тайлангуудыг бэлтгэсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.



Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
3. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр;
4. Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт;
5. Төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар;
6. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл;
7. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
8. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;
9. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;
10. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 14 нарийвчилсан горим, сорил төлөвлөсөн.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд харьяа 39 шүүхийн Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, төвлөрсөн төсвийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т заасны дагуу 7 шүүхийн Тамгын газрын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 27 шүүхийн Тамгын газарт “Зөрчилгүй” санал дүгнэлт, Булган аймгийн шүүхийн Тамгын газарт санал дүгнэлт өгөхөөс татгалзаж, 4 шүүхийн Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, төвлөрсөн төсвийн санхүүгийн тайланг аудитын түүвэрлэлтэд хамруулсан болно.

3.9.1 Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Булган аймгийн шүүхийн Тамгын газарт санхүүгийн аудитын санал дүгнэлт өгөхөөс татгалзсан /937.3 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай/



Булган аймаг дахь Төрийн аудитын газар санхүүгийн тайлан, баримт материалыг удаа дараа шаардан мэдэгдэл хүргүүлсэн ба тус шүүхийн Тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудитын дүгнэлт өгөхөөс татгалзаж 2018 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 86 тоот албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т “төсвийн шууд захирагч ... , жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх”, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “... байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.2 Санхүүгийн тайлагналын талаар

Итгэл үзүүлсэн 7, зөрчилгүй санал дүгнэлттэй 9, нийт 16 шүүхийн Тамгын газар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаатай бэлтгэснээс нягтлан бодох бүртгэлийн болон тоо тооцооллын алдаатай санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Тухайлбал:

- ✓ Үр дүнгийн тайлангийн урсгал зардлын дүн 1,803.6 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн програм шинэчлэлийг цаг хугацаанд хийлгээгүйтэй холбоотой байна.
- ✓ Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүүтэй гүйлгээ, болон бусад шалтгаанаар аудит хийгдсэн ба тухайн шүүхийн Тамгын газрын санхүүгийн тайлангийн тоо материалыг нийт 550.6 сая төгрөгөөр өөрчлөн нэгтгэл хийсэн байна.
- ✓ Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс санхүүжих дүнг төвлөрүүлэх шилжүүлгээр бууруулаагүйгээс 33.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд ба УСНББОУС-тай болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэл, тайлагналын холбогдох заавар, журмын дагуу байгууллагын санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайланг материаллаг бүх үзүүлэлтээр үнэн зөв, шударга илэрхийлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.3 Үндсэн хөрөнгийн талаар

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн бүртгэлд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- ✓ Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9 давхар 3,542 кв талбай бүхий 2,428.3 сая төгрөгийн өртөг бүхий конторы барилдаг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байрлаж үйл ажиллагаагаа явуулж байгаа;



- ✓ Захиргааны хэргийн шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаагаа явуулж буй барилгад Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба тайлант онд 50.6 сая төгрөгийн элэгдлийг байгуулан зардлаар хүлээн зөвшөөрсөн;
- ✓ Тайланд онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол шийдвэргүйгээр 403.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.4-т "... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх ... саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах",

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, ... шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг дагаж мөрдөж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.

3.9.4 Мөнгөн хөрөнгийн талаар

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх банкинд байгаа бэлэн мөнгийг дансны үлдэгдлийн баталгаатай тулган баталгаажуулахад 670.3 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. Тухайлбал Багануур дүүргийн шүүхийн Тамгын газар (670.5) сая төгрөг, Баянхонгор аймгийн шүүхийн Тамгын газар (2.0) сая төгрөг, Өвөрхангай аймгийн Хархорин суман дахь шүүхийн Тамгын газар 2.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Төрийн сантай дахин тооцоо нийлж банкин дахь бэлэн мөнгө зөв илэрхийлэгдсэнийг тулган баталгаажуулан залруулав.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, анхан шатны баримт бүрдлийг үнэн зөв бүрдүүлж, цаашид алдааг давтан гаргахгүй байх.

3.9.5 Авлага, өглөг, урьдчилж төлсөн зардлын талаар

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 22.8 сая төгрөгийн авлага, өглөгийн тооцоог тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй. Үүнд:

- ✓ Авлага, урьдчилж төлсөн зардлын 44.4 хувь буюу 17.7 сая төгрөг
- ✓ Өглөгийн 51.3 хувь буюу 5.1 сая төгрөг байна.



Барьцаа дансны өглөг 395.4 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “тасралтгүй”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...”, 20.2.6-д “ ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, авлага, өглөг, урьдчилж гарсан зардлыг улирал бүрийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулж, барьцаа дансны өглөг 395.4 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэх талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.6 Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоходоо Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2015 онд баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан элэгдэл тооцоход баримтлах хугацааг мөрдөөгүй байна. Үүнд:

- ✓ Шүүхийн байр, автогражийг 60 жилээр, бут сөөг, навчит модыг 55 жилээр,
- ✓ Компьютер, хувилагч машин, принтерийг 1-10 жилээр,
- ✓ Мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийг 1-10 жилээр,
- ✓ Тавилга эд хогшлын элэгдлийг 4-10 жилээр тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”,

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн Биет хөрөнгийн бүртгэлийн 7-д ШЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд нь “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах ёстой”,


Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацааг Төмөр бетон, угсармал байшин, ... тоосгон болон блокон дүүргэлттэй барилга 55 жилээр, компьютер, тооцоолон бодох техник хэрэгслийг 4 жилээр, Мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, программ хангамжийг 4 жилээр, ахуйн хэрэглээний хөргөгч, хөлдөөгчийг 4 жилээр, тавилга эд хогшлыг 8 жилээр...” гэж заасныг зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан элэгдлийг тооцох хугацааг баримталж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4,964.4 сая төгрөгийн үнэ бүхий зоорийн давхрын цутгалт хийгдсэн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Эрүү, иргэний шүүхийн цогцолборын үндсэн дүгээр барилгуулага Шүүхийн ерөнхий зөвлөлд балансаас балансад шилжүүлсэн байна.



Дээрх барилга байгууламж 2014 оноос хойш санхүүжилтгүйн улмаас барилга угсралтын ажил хийгдээгүй бөгөөд дуусаагүй барилга байгууламжийг хүлээн авч үндсэн хөрөнгийн дуусаагүй барилга байгууламжид 4,964.4 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Тухайн шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэж байна” гэж зааснаар шүүхэд 35 жил ажилласан шүүгчид 62 хувийн нэмэгдэл тооцогдохоор байхад өнөөдөр цалингийн нэмэгдлийг жил бүр нэмэгдэлтэй цалингаас 2 хувиар нэмэгдүүлсээр 88.5 хувийн нэмэгдэл тооцон сар бүр 0.8 сая төгрөгийн нэмэгдэл илүү олгож байна.

Дээрх хуулийн 23.3-т “Шүүгч нь ажлын ачаалал, бүтээмж, шийдвэрийн чанар зэрэгтэй уялдсан нэмэгдэл авах бөгөөд уг нэмэгдэл нь энэ хуулийн 8.3-т заасан мэргэшлийн үнэлгээний үр дүнгээс хамаарах ба нэмэгдлийн хэмжээ үндсэн цалингийн 50 хувь хүртэл байна”, 23.4-т “Энэ хуулийн 23.3-т заасан нэмэгдэл олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулж Улсын Их Хурал батална” /Энэ хэсгийг 2015 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/ гэж заасан байна.

3.11 ЗАВСРЫН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Цалингийн зардал
- Хичээл сургалт, үйлдвэрлэл дадлагын зардал

3.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 8,193.1 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 8,193.1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс аудитаар нягтлан бодох бүртгэлийн 756.5 сая төгрөгийн алдааг залруулж, 7.1 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 6 төлбөрийн акт тогтоож, 403.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 7,025.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 36 зөвлөмж хүргүүллээ.


3.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 190.9 сая төгрөгийн 45 зөвлөмж хүргүүлсэн ба Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудитын алба хяналт тавьж ажиллан 2017 оны жилийн эцсийн байдлаар зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01-1062 дугаар албан бичгээр ирүүлсэн болно.

3.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.



Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 50,209.6 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь буюу 502.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд

- Булган аймгийн Шүүхийн тамгын газарт санхүүгийн аудитын санал дүгнэлт өгөхөөс татгалзсан /937.3 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай/ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "... байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй",
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тушаал, шийдвэргүйгээр 403.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.4-т "... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх ... саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, ... шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ",
- Нийт 22.8 сая төгрөгийн авлага, өглөгийн тооцоог тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "тасралтгүй", 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...", 20.2.6-д "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.


Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна. Иймд "Хязгаарлалттай" санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дугаар хэсэгт үзүүлэв.

3.16 Аудитын үр өгөөжийн талаар

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна. Иймд "Хязгаарлалттай" санал дүгнэлт гаргаж байна.



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Шүүхийн ерөнхий зөвлөлийн санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 Санхүүгийн тайлангийн аудитын талаар

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

ҮАГ-ын ажиглалт

Булган аймгийн шүүхийн Тамгын газарт санхүүгийн аудитын санал дүгнэлт өгөхөөс татгалзсан. /937.3 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай/

Булган аймаг дахь Төрийн аудитын газар санхүүгийн тайлан, баримт материалыг удаа дараа шаардан мэдэгдэл хүргүүлсэн ба тус шүүхийн Тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудитын дүгнэлт өгөхөөс татгалзаж 2018 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 86 тоот албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т “төсвийн шууд захирагч ... , жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх”, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “ Төрийн аудитын байгууллага, түүний ажилтнууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай авах эрхтэй. Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлангийн хугацаа хоцроох, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулиудийг хэрэгжүүлж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн танилцуулсан болно. бүртгэлийг удирдлага, ажилтанд ажилтанд



4.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ТАЛААР

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

ҮАГ-ын ажиглалт

Итгэл үзүүлсэн 7, зөрчилгүй санал дүгнэлттэй 9, нийт 16 шүүхийн Тамгын газар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2,387.9 сая төгрөгөөр алдаатай бэлтгэснээс нягтлан бодох бүртгэлийн болон тоо тооцооллын алдаатай санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд ба УСНББОУС-тай болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэл, тайлагналын холбогдох заавар, журмын дагуу байгууллагын санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайланг материаллаг бүх үзүүлэлтээр үнэн зөв, шударга илэрхийлж ажиллах:

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

**4.3 Авлага, өглөг, урьдчилж төлсөн зардалын
ТАЛААР**

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №3

ҮАГ-ын ажиглалт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 22.8 сая төгрөгийн авлага, өглөгийн тооцоог тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй. Үүнд:

- ✓ Авлага, урьдчилж төлсөн зардлын 44.4 хувь буюу 17.7 сая төгрөг,
- ✓ Өглөгийн 51.3 хувь буюу 5.1 сая төгрөг байна.

Барьцаа дансны өглөг 395.4 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “тасралтгүй”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...”, 20.2.6-д “ ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, авлага, өглөг, урьдчилж гарсан зардлыг улирал бүрийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулж, барьцаа дансны өглөг 395.4 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэх:

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

4.4 Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №4

ҮАГ-ын ажиглалт

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоходоо Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2015 онд баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан элэгдэл тооцоход баримтлах хугацааг мөрдөөгүй байна. Үүнд:

- ✓ Шүүхийн байр, автогражийг 60 жилээр, бут сөөг, навчит модыг 55 жилээр,
- ✓ Компьютер, хувилагч машин, принтерийг 1-10 жилээр,
- ✓ Мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийг 1-10 жилээр,
- ✓ Тавилга эд хогшлын элэгдлийг 4-10 жилээр тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”,

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын НББ-ийн бодлогын баримт бичгийн Биет хөрөнгийн бүртгэлийн 7-д ШЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд нь “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах ёстой”,

Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацааг Төмөр бетон, угсармал байшин, ... тоосгон болон блокон дүүргэлттэй барилга 55 жилээр, компьютер, тооцоолон бодох техник хэрэгслийг 4 жилээр, Мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, программ хангамжийг 4 жилээр, ахуйн хэрэглээний хөргөгч, хөлдөөгчийг 4 жилээр, тавилга эд хогшлыг 8 жилээр...” гэж заасныг зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө буруу үнэлэгдэх, үрэгдэх, шамшигдах;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан элэгдлийг тооцох хугацааг баримтлаж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



5 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,006,624.8	938,938.3
МӨНГӨН ХӨРӨНГӨ	81.3	1,593.4
Банкинд байгаа бэлэн мөнгө	81.3	1,593.4
Төгрөг	81.3	1,593.4
АВЛАГА	39,035.1	29,598.4
Бусад авлага	23,388.4	21,025.9
УРЬДЧИЛГАА	5,590.9	10,251.0
БАРАА МАТЕРИАЛ	961,917.5	897,495.6
Хангамжийн материал	946,477.2	889,640.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	40,078,225.5	42,000,757.5
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	40,078,225.5	42,000,757.5
Биет хөрөнгө	39,310,712.7	41,291,074.4
Биет бус хөрөнгө	767,512.8	709,683.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	41,084,850.3	42,939,695.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР	80,658.9	9,915.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	80,658.9	9,915.4
Өглөг	80,658.9	9,915.4
Бусад өглөг	12,464.3	3,002.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	41,004,191.4	42,929,780.4
Засгийн газрын хувь оролцоо	41,004,191.4	42,929,780.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	17,284,911.7	17,284,911.7
Хуримтлагдсан үр дүн	16,632,593.2	18,559,529.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	41,084,850.3	42,939,695.8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	51,365,642.0	52,145,790.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,945,710.1	5,281,705.2
Нийтлэг татварын бус орлого	2,766,878.3	5,057,929.5
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,758,599.2	5,045,933.0
Тусламжийн орлого	178,831.8	223,775.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,419,931.8	46,864,085.7
Улсын төвлөрсөн төсвөөс	48,226,016.2	46,671,333.7
Нэмэлт санхүүжилтийн орлого	193,915.7	192,752.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	49,966,242.6	50,209,634.5
УРСГАЛ ЗАРДАЛ	49,966,242.6	50,209,634.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,053,802.1	48,357,247.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,447,110.9	33,680,882.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,770,428.3	3,749,789.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,345,401.8	1,490,071.5
Хангамж, бараа материалын зардал	2,224,174.6	2,367,654.5
Нормативт зардал	11,829.1	31,916.7
Эд хогшил, урсгал засварын зардал	787,968.8	1,302,946.4
Томилголт, зочны зардал	310,291.2	363,485.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,106,636.0	1,061,580.2
Бараа үйлчилгээний бусад зардал	4,049,961.5	4,308,921.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,912,440.5	1,852,386.6
Бусад урсгал шилжүүлэг	1,502,314.6	1,506,543.8
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	410,125.9	345,842.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,399,399.4	1,936,156.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,925.6	11,058.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,386,473.7	1,925,097.5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,594,987.9		39,594,987.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	22,902.5		22,902.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,617,890.4		39,617,890.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-		-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(172.6)		(172.6)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
Тайлант үеийн үр дүн	1,386,473.7		1,386,473.7
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,004,191.4		41,004,191.4
2017 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	41,004,191.4		41,004,191.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,838.5		1,838.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,006,029.9		41,006,029.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,347.0)		(1,347.0)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-		-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
Тайлант үеийн үр дүн	1,925,097.5		1,925,097.5
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	42,929,780.4		42,929,780.4

5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	49,341,047.5	47,706,426.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	583,349.3	385,329.3
Нийтлэг татварын бус орлого	583,349.3	385,329.3
Төсөв байгууллагын өөрийн орлого	33,950.4	148,422.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,757,698.2	47,321,097.3
Улсын төвлөрсөн төсвөөс	48,226,016.2	46,671,333.7
Нэмэлт санхүүжилтийн орлого	159,480.1	214,436.4
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	372,202.0	435,327.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,350,667.6	47,530,533.6
УРСГАЛ ЗАРДАЛ	49,350,667.6	47,530,533.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,064,205.3	45,225,889.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,415,007.0	33,684,470.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,777,505.5	3,735,683.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,362,829.6	1,486,832.3
Хангамж, бараа материалын зардал	2,216,990.8	2,288,447.1
Нормативт зардал	25,937.8	45,199.2
Эд хогшил, урсгал засварын зардал	2,768,518.2	1,856,905.4
Томилолт, зочны зардал	330,143.8	369,668.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,421,230.1	1,171,442.0
Бараа үйлчилгээний бусад зардал	746,042.5	587,241.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,286,462.3	2,304,644.3
Бусад урсгал шилжүүлэг	1,873,674.4	1,958,801.5
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	412,788.0	345,842.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(9,620.1)	175,893.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	289,305.9	174,380.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	289,305.9	174,380.9
Дотоод эх үүсвэрээр	289,305.9	174,380.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(289,305.9)	(174,380.9)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(298,926.0)	1,512.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	299,007.4	81.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	81.3	1,593.4

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	81.3	-	
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,731,333.7	46,407,848.7	323,485.0	99.3
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV)	46,731,333.7	46,407,848.7	323,485.0	99.3
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	46,731,333.7	46,407,848.7	323,485.0	99.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,022,247.4	44,898,864.1	123,383.3	99.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,660,063.5	33,647,048.3	13,015.2	100.0
Үндсэн цалин	31,452,613.0	31,218,273.0	234,340.0	99.3
Унаа хоолны хөнгөлөлт	1,778,586.4	1,617,335.0	161,251.4	90.9
Урамшуулал	428,864.1	811,440.3	(382,576.2)	189.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,739,948.7	3,734,345.7	5,603.0	99.9
Тэтгэврийн даатгал	2,391,640.9	2,388,052.9	3,588.0	99.9
Тэтгэмжийн даатгал	319,430.9	318,929.8	501.1	99.8
ҮОМШӨ-ний даатгал	287,276.4	286,870.8	405.6	99.9
Ажилгүйдлийн даатгал	67,418.2	67,317.4	100.8	99.9
Эрүүл мэндийн даатгал	674,182.3	673,174.7	1,007.6	99.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,508,503.5	1,486,832.3	21,671.2	98.6
Гэрэл, цахилгаан	372,360.7	375,268.7	(2,908.0)	100.8
Түлш, халаалт	817,756.1	800,760.1	16,996.0	97.9
Цэвэр, бохир ус	106,829.8	99,287.4	7,542.4	92.9
Байрны түрээс	211,556.9	211,516.2	40.7	100.0
Хангамж, бараа материалын зардал	2,278,258.6	2,274,847.6	3,411.0	99.9
Бичиг хэрэг	779,907.5	829,492.4	(49,584.9)	106.4
Тээвэр, шатахуун	610,077.2	591,580.2	18,497.0	97.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	561,188.6	506,593.1	54,595.5	90.3
Ном, хэвлэл	49,900.0	48,258.6	1,641.4	96.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,658.3	6,720.8	1,937.5	77.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	268,527.0	292,202.5	(23,675.5)	108.8
Нормативт зардал	45,281.8	45,199.2	82.6	99.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	45,281.8	45,199.2	82.6	99.8
Эд хогшил, урсгал засварын зардал	1,924,659.6	1,923,833.6	826.0	100.0
Багаж, техник, хэрэгсэл	510,909.6	490,195.7	20,713.9	96.0
Урсгал засвар	1,413,750.0	1,433,637.9	(19,887.9)	101.4
Томилолт, зочны зардал	377,586.9	361,148.7	16,438.2	95.7
Дотоод албан томилолт	377,586.9	361,148.7	6,438.2	95.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,166,920.9	1,104,858.3	62,062.6	94.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	570,382.6	513,319.1	57,063.5	90.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,232.6	10,182.0	1,050.6	90.7
Даатгалын үйлчилгээ	508,379.3	507,974.7	404.6	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	12,751.3	10,269.5	2,481.8	80.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,876.7	2,702.2	174.6	93.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	55,586.3	55,559.0	27.3	100.0
Газрын төлбөр	5,712.1	4,851.8	860.3	84.9
Бараа үйлчилгээний бусад зардал	321,023.9	320,750.5	273.4	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	94,784.1	94,720.7	63.4	99.9



**Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	226,239.8	226,029.9	209.9	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,709,086.3	1,508,984.6	200,101.7	88.3
Бусад урсгал шилжүүлэг	1,709,086.3	1,508,984.6	200,101.7	88.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	124,996.9	3,186.3	121,810.6	2.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,185,287.9	1,119,763.7	65,524.2	94.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	398,801.5	386,034.6	12,766.9	96.8
VI.ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	46,731,333.7	46,408,691.4	322,642.3	99.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,671,333.7	46,327,146.8	344,186.9	99.3
Улсын төсвөөс санхүүжих	46,671,333.7	46,327,146.8	344,186.9	99.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	60,000.0	81,544.6	(21,544.6)	135.9
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000.0	81,544.6	(21,544.6)	135.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	924.0	(924.0)	
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	-	1,297,735.3	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	155	155	-	100
Төсвийн байгууллага	155	155	-	100
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,961	1,888	73	96.3
Удирдах ажилтан	173	173	-	100
Гүйцэтгэх ажилтан	1,574	1,501	73	95.4
Үйлчлэх ажилтан	214	214	-	100

